



Arlington Public Schools

Department of Teaching and Learning · 2110 Washington Boulevard · Arlington, Virginia 22204

ELLS-ийн ACCESS шалгалтад хүүхдээ оролцуулахаас татгалзах эцэг эхэд зориулсан маягт

Виржиниа мужийн Боловсролын Газар (VDOE) болон АНУ-ын Боловсролын Яамнаас тогтоосны дагуу Виржиниа мужийн ELP 1-4 түвшний болон биеэр шалгалтад хамрагдаж байгаагүй сурагчдад зориулан, цар тахлын үед ч гэсэн англи хэл суралцагчийн (ELL) шалгалт ACCESS-ийг зохион байгуулах болно. Энэхүү албан ёсны шалгалтаар багш суралцагчийнхаа англи хэлний сонсох, ярих, унших бичих ур чадварт гарсан ахиц дэвшлийн талаар тун хэрэгтэй мэдээлэл олж авах боломжтой. Уг шалгалтын үр дүнг суралцагч англи хэлний бүрэн чадвартай болсон эсэхийг тогтоож, зохих хичээлд нь хуваарилах ба багш нар тухайн хүүхдийн хэлний ур чадварын ахиц дэвшлийг үнэлэхэд ашигладаг. Түүнчлэн хүүхдийн хэл сурах хэрэгцээг хангаж байгаа эсэх мөн англи хэлийг үргэлжлүүлэн сурахад шаардлагатай дэмжлэгийг үзүүлж чадаж буй эсэхээ багш нар дүгнэхэд ашиглах нь бий.

Нэг талаар бид уг үнэлгээнд хүүхдээ хамруулахыг уриалж байгаа ч хүүхдийн аюулгүй байдлыг хангах талаар олон арга хэмжээ хэрэгжүүлж байгаагаас үл шалтгаалан эцэг эхчүүд хүүхдээ сургуульд очиж шалгалт өгүүлэхээс болгоомжилж байгааг бид ойлгож байна. Хүүхдээ уг шалгалтад оролцуулахыг хүсэхгүй байгаа эцэг эх доорх мэдэгдэлтэй танилцаж, хуудасны төгсгөлд байгаа маягтыг бөглөн сургуулийн шалгалтын албанд илгээх хэрэгтэй.

- ELL-ийн шалгалтын ACCESS үнэлгээгээр үнэлүүлээгүй тохиолдолд хүүхдэд минь академик торгууль ноогдуулахгүй. Сурагч ийм тохиолдолд ч анги дэвшин суралцах бөгөөд SOL шалгалт өгөх эрхтэй хэвээр байна. Гэхдээ тэд VDOE-ийн тодорхойлсноор “Англи хэлний чадвартай” болж чадахгүй.
- ELL-ийн шалгалтын ACCESS нь сурагчдын мэдлэг хэр байгааг олж тогтооход сургуульд тусалдаг бөгөөд хүүхэд бүрийн англи хэлний ур чадварт гарч буй ахиц дэвшлийн талаарх мэдээллээр багшийг хангадаг. Хэрвээ хүүхэд минь уг шалгалтыг өгөхгүй бол түүний түвшнийг тогтоох ажил хойшлогдож, сонсох, ярих, унших, бичих ур чадварт нь гарч буй ахиц дэвшлийг сургууль үнэлэх боломжгүй болох магадлалтай.
- Англи хэл суралцагчийн сургалтад дахин орохгүйн тул англи хэл сурч байгаа сурагчид ELL-д зориулсан WIDA ACCESS дээр 4.4 ба түүнээс дээш оноо авах ёстой. Энэхүү оноог авагсдыг Англи хэлний мэдлэгтэй хэмээн үздэг. Энэ жил уг шалгалтыг өгөхөөс татгалзсанаар миний хүүхдийн англи хэлний бүрэн мэдлэгтэй болохыг тогтоох боломжгүй болно.

Хэрвээ танд зөвшөөрөл өгөхөөс татгалзах энэхүү процедурын талаар асууж тодруулах зүйл байвал сургуулийнхаа Тестийн зохицуулагчтай холбоо барина уу. Та мөн үнэлгээний дэд захирал Бетти Швобел-Миллстэй betty.mills@apsva.us эсвэл 703-963-2449 утсаар холбогдож болно.

Сурагчин нэр _____ Анги _____

Сургууль _____

Энэхүү маягтад гарын үсэг зурснаар ELL-ийн ACCESS шалгалтын зорилгыг ойлгосон бөгөөд хүүхдээ оролцуулахыг татгалзсанаас үүдэн гарах үр дагаврын талаар уншсан бөгөөд ойлгож байгаагаа баталж байна.

Эцэг эх/Асран хамгаалагчийн гарын үсэг _____ Огноо _____